



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 684

таний ны № т

Г БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ  
СҮМҮН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мэрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Баттулгын сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мэрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мэрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021381

Мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Баттулга Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Баттулгын мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Б.Баттулгад

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
сонгуульд бие даан нэр дэвшигч Байгалмаагийн Баттулга  
миний мөрийн хөтөлбөр

1. Өвөлжөө, хаваржаа, зуслангийн бүсийг хуваарийн дагуу ашигладаг болох санаачилгыг дэмжиж малчиттай хамтран ажиллана
2. Нийтийн эзэмшлийн газрууд болох хужир мараатай газруудад бусад багийн отрын малчдыг хэт олон хоног байлгах дургүй нутгийн малчдын санаачлагыг дэмжиж хамтран ажиллах
3. Отрын малчид нэг нэгнээ хүндэтгэн тухайн нутгийн малчдыг мал, хашаа хороог ариг гамтай хэрэглэх, дайран өнгөрдөг соёл, ёс зүйтэй болгож хамтран ажиллах
4. Залуучуудын урлаг, спортын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг болоход анхаарч сумын удирдлага, байгууллагад уламжлан ажиллана
5. Хот айлаараа хамтран боломжтой газруудад худаг гаргуулах, дундын өмчлөлд хамтран эзэмших
6. Хадлангийн талбайнуудыг дахин хуваарилах санал нутгийн иргэдээс гарвал дэмжиж уламжлан ажиллах
7. Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн цаг үед Шарга зэрэг багийн нутагт ихээр орж ирдэг, дайран өнгөрдөг адuu, сарлагны асуудлаар зэргэлдээх сумдтай хамтран ажиллаж шийдвэрлэх, тогтоох гаргах ажлыг багийн иргэд засаг даргатай хамтран тогтмол зохион байгуулах
8. Ногоон тэжээл тариалах ажлыг Баянзүрх, Баянхайрхан багийн нутаг дахь сумын тариалангийн талбайд хийх саналыг сумын удирдлагуудад уламжлах, газар тариалангийн компанийг талбайнхаа 10 хүртэл хувьд ногоон тэжээл тарих хуулийг баримтлан ажиллана

2024.07.24

Баян-Агт сум, Шарга баг